



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 702

Улаанбаатар хот

Журам, маягтын загвар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8.1.10, 9.1.2, 12.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Банкны зээлд барьцаалагдах эд хөрөнгөтэй холбоотой Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагаа, мэдээллийг банктай солилцох, мэдээлэл ашиглах нөхцөлийг хялбаршуулах, иргэд, хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Барьцааны эд хөрөнгөтэй холбоотой эрхийн улсын бүртгэлийн лавлагаа, мэдээллийг банкинд цахим хаягаар олгох журам"-ыг нэгдүгээр, "Эд хөрөнгийн талаарх лавлагаа, мэдээллийг цахим хаягаар солилцох маяг"-ын загварыг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг нийслэлийн Улсын бүртгэлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Содномдоржид, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Туяад үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ



**БАРЬЦААНЫ ЭД ХӨРӨНГӨТЭЙ ХОЛБООТОЙ ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЛИЙГ БАНКИНД ЦАХИМ ХАЯГААР ОЛГОХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар банк, банк бус санхүүгийн байгууллагын гэрээгээр барьцаалагдах эд хөрөнгөтэй холбоотой эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх лавлагаа, мэдээллийг Улсын Бүртгэлийн ерөнхий газар /цаашид "Бүртгэлийн байгууллага" гэх/, Банк, банк бус санхүүгийн байгууллага /цаашид "Банкны байгууллага" гэх/-аас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журамд дурдагдсан зарим нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.2.1. "мэдээлэл, лавлагаа" гэдэгт гэрээний дагуу барьцаалагдсан эсхүл барьцаалагдах эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн тухай болон үүрэг ногдуулсан бүртгэл бүртгэгдсэн эсэх, хууль, хяналтын байгууллагаас эрх түдгэлзүүлсэн эсэх тухай лавлагаа, мэдээлэл /цаашид "лавлагаа" гэх/-ийг;
 - 1.2.2. "цахим шуудангийн баталгаат хаяг" гэдэгт Бүртгэлийн байгууллага болон банкны байгууллага хооронд лавлагаа олгох зорилгоор бичгээр харилцан солилцсон албан ёсны цахим хаягийг;
- 1.3. Цахим шуудангийн баталгаат хаягаар лавлагаа өгөхдөө Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журмын холбогдох заалт болон энэхүү журмыг баримтлан ажиллана.

ХОЁР. ЛАВЛАГАА ОЛГОХ ХЭЛБЭР

- 2.1. Банкны байгууллагаас цахим шуудангийн баталгаат хаягаар илгээсэн хүсэлтийг үндэслэн Бүртгэлийн байгууллага нь гэрээний дагуу барьцаалагдах болон барьцаалагдсан эд хөрөнгийн улсын бүртгэлийн лавлагааг цахим файл хэлбэрээр олгоно.
- 2.2. Энэ журмын 2.1-д заасан үйл ажиллагааг Бүртгэлийн байгууллагаас тухайн дүүргийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга, банкны байгууллагын салбарын захирал хариуцан зохион байгуулах бөгөөд талууд тус тусдаа цахим шуудангийн баталгаат хаягтай байна.

ГУРАВ. ЛАВЛАГАА ОЛГОХ, АШИГЛАХ

- 3.1. Банкны байгууллага нь энэ журмын 1.2-т заасан лавлагааг авах хүсэлтээ 2 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу жагсаалт үйлдэн тухайн эд

хөрөнгө оршин байгаа дүүргийн Бүртгэлийн хэлтсийн цахим шуудангийн баталгаат хаягаар хүргүүлнэ.

- 3.2. Банкны байгууллага нь энэ журамд заасан агуулга бүхий лавлагаа авахдаа хуульд заасан хэлбэрээр өмчлөгчөөс итгэмжлэл авсан байх бөгөөд батлагдсан маягтад итгэмжлэлийн дугаар, нотариатчийн хувийн дугаарыг тэмдэглэнэ. Банкны байгууллага нь шаардлагатай тохиолдолд итгэмжлэлийг бүртгэлийн байгууллагад гарган өгөх үүрэгтэй.
- 3.3. Банкны байгууллага лавлагаа авахаар ирүүлсэн маягтад үйлчилгээний хөлс төлсөн хэлбэрийг тэмдэглэнэ. Үйлчилгээний хөлсийг тухайн үед мөрдөгдөж байгаа Засгийн газрын тогтоолын дагуу төлнө.
- 3.4. Тухайн дүүргийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга энэ журмын 2.2-т зааснаар лавлагааг хүлээн авч хариуцсан улсын бүртгэгчид хуваарилна.
- 3.5. Улсын бүртгэгч нь лавлагааг батлагдсан маягтын дагуу гаргаж, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн даргад өгөх бөгөөд хувийн хэрэгт лавлагааг 1 хувь үйлдэж хавсаргана.
- 3.6. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга хариуг батлагдсан маягтын дагуу жагсаалтаар гарган нэгтгэж, улсын ахлах бүртгэгчийн тэмдгээр баталгаажуулан, хүсэлт ирүүлсэн банкны байгууллагын цахим хаягаар илгээнэ. Лавлагааны төлбөр төлөгдсөн тохиолдолд лавлагаа өгнө.
- 3.7. Банкны байгууллага нь энэ журмын 1.2-т заасан лавлагааг зөвхөн үндсэн үйл ажиллагааны хүрээнд барьцааны гэрээ байгуулахтай холбоотой үйл ажиллагаанд ашиглана.
- 3.8. Давхар хяналтын зорилгоор лавлагаа солилцох цахим шуудан нь үндсэн хаягаас гадна Нийслэлийн Улсын бүртгэлийн газар болон Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газар, Тамгын газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн баталгаат цахим хаягт давхар хүргэгдэхээр зохион байгуулагдана.

ДӨРӨВ. МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ БАЙДЛЫГ ХАНГАХ, ХЯНАЛТ ТАВИХ

- 4.1. Бүртгэлийн байгууллагаас олгож буй лавлагааны үнэн зөв байдал, түүний баталгааг Бүртгэлийн байгууллага хариуцна.
 - 4.1.1. Улсын бүртгэгч нь холбогдох хууль, журмын дагуу өөрийн гаргаж өгсөн лавлагааны үнэн зөв байдлыг хариуцна. Лавлагааны нэгтгэлийн үнэн зөвийг нэгтгэсэн тасгийн дарга хариуцна.
 - 4.1.2. Цахим шуудангаар лавлагаа солилцох үйл ажиллагаанд тухайн дүүргийн бүртгэлийн хэлтсийн дарга болон нийслэлийн Улсын бүртгэлийн газрын Эд хөрөнгийн бүртгэл хариуцсан хяналтын улсын байцаагч хяналт тавина.
- 4.2. Банкны байгууллага нь тухайн эд хөрөнгийн өмчлөгчөөс албан ёсны зөвшөөрөл аваагүй тохиолдолд лавлагаа авахыг хориглоно.
- 4.3. Лавлагаа хүлээн авагч Банкны байгууллага мэдээллийн аюулгүй байдлыг холбогдох хууль тогтоомж болон байгууллагын дотоод журамд заасны дагуу хангана.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын
2013 оны 702 тоот тушаалын 2 дугаар хавсралт



ЭД ХӨРӨНГИЙН ТАЛААРХ ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЛИЙГ
ЦАХИМ ХАЯГААР СОЛИЛЦОХ МАЯГТ

Банкны байгууллагаас ирүүлэх мэдээлэл						Бүртгэлийн байгууллагаас хүргүүлэх мэдээлэл		
Д/д	Эд хөрөнгийн улсын бүртгэлийн дугаар	Эд хөрөнгийн байршлын хаяг	Өмчлөгчийн овог, нэр	Регистрийн дугаар	Итгэмжлэл		Лавлагааны дугаар	Үүрэг ногдуулсан бүртгэл бүртгэгдсэн эсэх
					Нотариатчийн хувийн дугаар	Итгэмжлэлийн дугаар		Хууль, хяналтын байгууллагаас эрх түдгэлзүүлсэн эсэх
1								
2								
3								
4								
5								

Үйлчилгээний хөлс төгрөгийг дансанд он сар өдөр төлөв.

/Энд үйлчилгээний төлбөр ямар хэлбэрээр төлөгдсөн болохыг тэмдэглэнэ/

Лавлагаа, мэдээллийг өмчлөгчийн итгэмжлэлийг үндэслэн авч байгааг хариуцсан:

Лавлагаа, мэдээллийг эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас үнэн зөв гаргасан:

Банкны байгууллагын эрх бүхий ажилтан

Улсын бүртгэлийн байгууллагын эрх бүхий ажилтан

..... /албан тушаал/

..... /албан тушаал/

/Тамга/ /овог нэр/

/Тэмдэг/ /овог нэр/

Банк, салбарын нэр.....

..... /дүүргийн/ бүртгэлийн хэлтэс